

2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр

№ 2021/01

Улаанбаатар хот

“Улаанбаатар БҮК” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн бүртгэл цахим хэлбэрээр 2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 11:00 цаг хүртэл явагдсан ба хурал 11 цаг 25 минутанд эхлэв.

Хурлын дарга: Д. Нямхүү

Зохион байгуулах комиссын гишүүд: Н. Хунцэнгэл, Д. Байгальмаа, Х. Анхцэцэг

Тооллогын комиссын гишүүд: Д. Пүрэвцэрэн, Л. Билгүүн, Г. Сувдаа

Хурлын ирц:

Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дарга Д. Пүрэвцэрэн хурлын ирцийг танилцуулав:

“Улаанбаатар БҮК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд саналын эрхтэй 128,333,441 ширхэг хувьцаа буюу нийт саналын эрхтэй хувьцааны 97,56 хувийг төлөөлсөн 10 хувьцаа эзэмшигч оролцсон тул Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 3.1 дэх заалт, 67 дугаар зүйлийн 3.8 дахь заалт, 69 дүгээр зүйлийн 1 дэх заалт, Компанийн дүрмийн 7.10 дахь заалт, Тооллогын комиссын санал хураалтын дүнг тус тус үндэслэн Хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцов.

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид:

- | | |
|--------------------|---|
| 1. Чапанов Мухамед | /“Улаанбаатар менежмент” ХХК/ |
| 2. Д. Сувдаа | /“Тулгат чандмань баян” ҮЦК ХХК, “Гүүдсек” ҮЦК ХХК/ |
| 3. Х. Номинтуяа | /“Ард секюритиз” ҮЦК ХХК/ |
| 4. Ж. Энхтунгалаг | /“Өндөрхаан инвест” ҮЦК ХХК/ |
| 5. Б. Ганболд | /“Би Ди Сек” ҮЦК ХХК/ |
| 6. Н. Сэлэнгэ | /“Санар” ҮЦК ХХК/ |
| 7. М. Шигшээ | /“Тэнгэр капитал” ҮЦК ХХК/ |
| 8. З. Уламдэлгэр | /“Санар” ҮЦК ХХК/ |
| 9. Д. Батдэлгэр | /“Ард секюритиз” ҮЦК ХХК/ |
| 10. Б. Баярмаа | /“Би Ди Сек” ҮЦК ХХК/ |

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг танилцуулах, батлах тухай;
2. Ногдол ашгийн талаарх ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах тухай;
3. “Улаанбаатар БҮК” ХК-ийн 2021 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшингийн талаар танилцуулах тухай;
4. ТУЗ-ийн гишүүдийг томилох тухай;
5. ТУЗ-ийн 2021 оны үйл ажиллагааны төсөв батлах тухай;

Хурлын дарга Д.Нямхүү ээлжит хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулсныг Хувьцаа эзэмшигчид батлав.

Хэлэлцэх асуудал-1: “Улаанбаатар БҮК” ХК-ийн 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг танилцуулах, батлах тухай;

“Улаанбаатар БҮК” ХК-ийн 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг Гүйцэтгэх захирал Х. Золжаргал танилцуулав.

ТУЗ-ийн дарга Д. Нямхүү: Гүйцэтгэх захирал Х. Золжаргалын танилцуулсан Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан дээр нэмж хэлэхэд манай компани ялангуяа 2019-2020 онд бүтээн байгуулалт, тоног төхөөрөмж, үйл ажиллагааны хувьд асар их шинэчлэлт хийснээр өдгөө Монгол улсад чанарын шаардлага хангасан хамгийн өндөр хүчин чадал бүхий үйлдвэр болон хөгжсөн байна. “Оюу толгой” ХХК-иас зарлагдсан томоохон төсөл, тендерт оролцон, хамтран ажиллаж байгаа нь манай компанийн бүтээгдэхүүн, үйл ажиллагаа олон улсын стандартад нийцэж байгааг харуулж байна. Үүнээс гадна манай компани бетоныхоо чанарыг сайжруулахын тулд бүрэн хүчин чадалтай техник, тоног төхөөрөмж суурилуулсан, мөн эвдэрч, зогсонги байдалтай байсан олон тооны краныг засварлаж, хэвийн ажиллагаанд оруулсан. Түүнчлэн гадна элс, хайрга хадгалах талбайг шинэчилж, өвлийн улиралд ч угаасан хайрга ашиглах хүчин чадалтай агуулах төхөөрөмж байгуулсан.

Хувьцаа эзэмшигч Д. Батдэлгэр: Компанийн 2020 оны жилийн үйл ажиллагааны тайланг сонслоо. Надад 2 асуулт байна:

1. Танай компани 2020 онд оролцож байсан Төмөр замын бүтээн байгуулалтын төсөлдөө энэ жил дахин оролцох уу?
2. Засгийн газраас хэрэгжүүлж байгаа 3 их наяд төгрөгийн “Орон сууцжуулах хөтөлбөр”-т танай компани яаж оролцох вэ? Хэрэв оролцвол энэ нь компанийн ашиг орлогод хэрхэн нөлөөлөх вэ?

Гүйцэтгэх захирал Х. Золжаргал: Бид төмөр замын бүх төрлийн төсөл хөтөлбөрт оролцоход бэлэн байна. Энэ талаар Засгийн газраас хэрэгжүүлж эхэлбэл бид оролцоно. 3 их наяд төгрөгийн хөтөлбөрт ч оролцоход бэлэн. Энэ төсөл манай компанийн үйл ажиллагаанд сайнаар нөлөөлнө.

ТУЗ-ийн дарга Д. Нямхүү: Төмөр замын бүтээн байгуулалтаар нийт 412 км зам тавигдсан. Үргэлжлүүлээд энэ оноос эхлэн Сүхбаатар аймаг руу 314 км зам тавигдахаар яригдаж байгаа. Энэ ажил эхэлбэл бид оролцоход бэлэн.

Хувьцаа эзэмшигч Д. Батдэлгэр: Би танай компанийн хувьцааг 2020 оноос сонирхож эхэлсэн. Өөрөө барилгын чиглэлийн хүн биш боловч танай компанийн үйл ажиллагааг сонирхож, бүтээгдэхүүн үйлчилгээний талаар мэдээллүүдтэй байнга танилцаж байгаа. Хувьцааны үнэ ханшийн талаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгнө үү. Хувьцааны үнэ ямар байгаа вэ? Хямд байгаа юу? Одоо байгаа хувьцааны үнэ өнөөгийн зах зээлд хэр нийцэж байна вэ? Танай компани том төслүүд дэр ажилладаг учраас үйл ажиллагаа нь нэлээн сайн байгаа байх. Цаашид хувьцаа эзэмшигчдэд хэрхэн яаж хандах вэ?

ТУЗ-ийн дарга Д. Нямхүү: Би та бүхэнд ногдол ашгийн талаар танилцуулахдаа энэ талаар маш тодорхой тайлбар хийх болно.

Өөр асуулт санал гараагүй тул компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг танилцуулсны дагуу “Улаанбаатар БҮК”

ХК-ийн 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг “хангалттай” гэж үзэн нийт хувьцаа эзэмшигчид 100 хувийн саналаар дэмжив.

Санал хураалтын дүн:

Зөвшөөрсөн:8

Татгалзсан: 0

Санал хураалтын дүн: 100%

Санал хураалтын дүнг үндэслэн Тооллогын комиссын дарга Д. Пүрэвцэрэн Тогтоолын төслийг танилцуулж хурлын дарга Д. Нямхүү батлав.

ШИЙДВЭР:

“Улаанбаатар БҮК” ХК-ийн 2019 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан “хангалттай” гэж дүгнэгдэв.

Танилцуулах асуудал-2: Ногдол ашгийн талаарх ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах тухай;

Ногдол ашгийн талаарх ТУЗ-ийн шийдвэрийг ТУЗ-ийн дарга Д. Нямхүү танилцуулав.

ТУЗ-ийн дарга Нямхүү: Манай компанийн хувьцаа эзэмшигчдийг хуулийн этгээд болон хувь хүмүүс бүрдүүлж байна. Компанийн дүрмийн санг нэмэхийн тулд дахин хөрөнгө оруулалт хийж, хувьцаа хуваах төсөл хэрэгжүүлснээр хувьцааны тоог нийт 131,547,500 ширхэг болгосон. 2020 онд нэгж хувьцааны ногдол ашгийг 4 төгрөгөөр тараасан. Энэ жил манай компани ашигтай ажилласан тул нэгж хувьцааны ногдол ашгийг 30 төгрөгөөр тогтоосон. Ингэснээр нийт 3,946,425,000 төгрөгийн ногдол ашиг “ҮЦТХТ” ХХК-иар хувьцаа эзэмшигчдэд тараагдана.

Хувьцаа эзэмшигч Д. Батдэлгэр: УБ БҮК ХК нь нийт хувьцааныхаа 3 хувийг иргэдэд тараасан гэж үзэж байна, нэмж хөрөнгө оруулалт босгох уу, мөн залуу боловсон хүчин шинээр танай компанид хэр их орж ажиллаж байна вэ?

ТУЗ-ийн дарга Нямхүү: Нийт хувьцааны 97,5 хувийг “Улаанбаатар менежмент” ХХК эзэмшиж байна, үлдсэн 2,5 хувийг бусад хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна. Манай компани “Монголын хөрөнгийн бирж”-тэй байнга хамтран ажиллаж байгаа. Хувьцаа эзэмшигчид маань брокер диллерийн компаниудаар дамжуулан хувьцааны ногдол ашгаа авсаар байгаа. Мөн дахин нэмэлтээр хувьцаа худалдаж авах хүсэлтэй байвал зах зээл дээр манай хувьцаа хангалттай байгаа гэж үзэж байна. Мөн боловсон хүчний асуудлын хувьд компанийнхаа удирдлагуудыг өөрчилсөн. Манай компанийн Гүйцэтгэх захирлаар олон салбарт ажиллаж байсан, компанийн бүтээн байгуулалт, хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулах ажлын арвин их туршлагатай Х. Золжаргал томилогдон ажиллаж байна. Түүнчлэн бид шинэ залуу боловсон хүчнүүдийг компанидаа ажиллуулснаар компанийн нийт ажилчдын дийлэнх хувийг залуу боловсон хүчин эзэлж байна.

Хувьцаа эзэмшигч Д. Батдэлгэр: Нэмэлтээр зах зээлд IPO хийх үү? Нэмж хөрөнгө төвлөрүүлэх үү?

ТУЗ-ийн дарга Нямхүү: Бидэнд шаардлагатай байсан хөрөнгө оруулалтыг манай компани өөрсдийнхөө үйл ажиллагаагаар олоод авчихсан учраас дахин хөрөнгө төвлөрүүлэх шаардлагагүй гэж үзэж байна.

Танилцуулах асуудал-3: “Улаанбаатар БҮК”ХК-ийн 2021 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшингийн талаар танилцуулах тухай;

“Улаанбаатар БҮК”ХК-ийн 2021 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшингийн талаар Гүйцэтгэх захирал Х. Золжаргал танилцуулав.

Хэлэлцэх асуудал- 4: ТУЗ-ийн гишүүдийг томилох тухай:

ТУЗ-ийн дарга Д. Нямхүү Нэр дэвшүүлэх хорооноос ТУЗ-д нэр дэвшүүлсэн 9 гишүүнийг танилцуулав. Т.Мэндсайхан өөрийн хүсэлтээр ТУЗ-ийн хараат бус гишүүнээс чөлөөлөгдсөн тул Ч. Энхбатыг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилохоор нэр дэвшүүлснийг танилцуулав.

ТУЗ-д нэр дэвшүүлсэн гишүүдэд куммулятив аргаар санал хураав:

Санал хураалтын дүн:

Зөвшөөрсөн:8

Татгалзсан: 0

Санал хураалтын дүн: 100%

1.1. Ердийн гишүүд

- 1.Д. Нямхүү-д өгсөн санал: 128,322,941 буюу 11,11%
- 2.Д. Мөнхөө-д өгсөн санал: 128,322,941 буюу 11,11%
- 3.Х.Ю.Хамхоев-д өгсөн санал: 128,322,941 буюу 11,11%
- 4.М.А.Чапанов-д өгсөн санал : 128,322,941 буюу 11,11%
- 5.Х. Золжаргал-д өгсөн санал: 128,322,941 буюу 11,11%
- 6.О. Басанхүү-д өгсөн санал : 128,322,941 буюу 11,11%

1.2. Хараат бус гишүүд

1. С.Б.Громов-д өгсөн санал: 128,322,941 буюу 11,11%
2. Г. Цогнэмэх-д өгсөн санал: 128,322,941 буюу 11,11%
3. Ч. Энхбат-д өгсөн санал: 128,322,941 буюу 11,11%

Санал хураалтын дүнг үндэслэн Тооллогын комиссын дарга Д. Пүрэвцэрэн Тогтоолын төслийг танилцуулж, хурлын дарга Д. Нямхүү батлав.

ШИЙДВЭР:

ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдээр дараах гишүүдийг сонгохоор шийдвэрлэв.

Үүнд:

1.1. Ердийн гишүүд

- 1.Д. Нямхүү
- 2.Д. Мөнхөө
- 3.Х.Ю.Хамхоев
- 4.М.А.Чапанов
- 5.Х. Золжаргал
- 6.О. Басанхүү

1.2. Хараат бус гишүүд

1. С.Б.Громов
2. Г. Цогнэмэх
3. Ч. Энхбат

Хэлэлцэх асуудал- 5: ТУЗ-ийн 2021 оны үйл ажиллагааны төсөв батлах тухай;

ТУЗ-ийн 2021 оны төсвийн талаар ТУЗ-ийн дарга Д. Нямхүү танилцуулсан ба ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллыг тэдний идэвх зүтгэл, хувь нэмэр, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний өөрчлөлт, гадаад валютын ханшийн өсөлт зэрэгтэй уялдуулан нэмсэн

талаар, түүнчлэн ТУЗ-ийн гишүүдэд зориулагдсан хурлын танхим байдаггүй тул хурлын танхим шинээр байгуулж, тохижуулах талаар тайлбарлав.

Хувьцаа эзэмшигч М. Шигшээ: Хорио цээрийн үед цемент болон түүхий эдийн нийлүүлэлт ямар байна вэ? Эдгээрийн үнийн өсөлт нь танай компанид хэр зэрэг нөлөөлж байна вэ?

Гүйцэтгэх захирал Х. Золжаргал: Манайх цементээ “Монцемент” ХХК-иас худалдаж авдаг. Энэ байгууллагаас задгайгаар цемент худалдаж авдаг комданиудаас манай компани хамгийн том нь. Бид хамтран ажиллах гэрээгээ 1 жилээр нь байгуулдаг. Цемент нийлүүлэх ажлыг тасалдуулахгүй хэвийн явуулдаг бидний найдвартай түнш юм.

Хувьцаа эзэмшигч М. Шигшээ: Танай компанийн бүтээгдэхүүний үнэд өөрчөлт орсон уу?

Гүйцэтгэх захирал Х. Золжаргал: Манай компани элс, хайрга, цемент, арматур гэсэн 4 үндсэн төрлийн түүхий эд ашигладаг. Одоогийн байдлаар зах зээлд цемент, арматурын үнэ нэмэгдсэн. “Монцемент” ХХК цементийнхээ үнийг нэмсэн учраас манайх бүтээгдэхүүнийхээ үнийг бага зэрэг нэмсэн. Манай компани 600 марк, 1000 марк, 1200 марк гэх мэт өндөр маркийн бетон үйлдвэрлэдэг. Гэсэн хэдий ч бид цаашдаа бүтээгдэхүүнийхээ үнийг аль болох огцом, шууд нэмэхгүй байх тал дээр анхаарч ажиллаж байна.

ТУЗ-ийн дарга Нямхүү: Өөр санал, асуулт байхгүй бол ТУЗ-ийн 2021 оны үйл ажиллагааны төсвийг батлах талаар санал хураая.

Санал хураалтын дүн:

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 0

Санал хураалтын дүн: 100%

Санал хураалтын дүнг үндэслэн Тооллогын комиссын дарга Д. Пүрэвцэрэн Тогтоолын төслийг танилцуулж хурлын дарга Д. Нямхүү батлав.

ШИЙДВЭР:

ТУЗ-ийн 2021 оны үйл ажиллагааны төсөв 187,138,000 төгрөгөөр батлагдав.


ТУЗ-ийн дарга Нямхүү: 2021 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хувьцаа эзэмшигчид маань ногдол ашгаа авч болно. Өмнө нь авч амжаагүй байсан ногдол ашгаа мөн адил нөхөж авч болно. Ингээд өөр асуух зүйлгүй бол өнөөдрийн хурлаа өндөрлөө. “Улаанбаатар БҮК” ХК-ийн ээлжит хурал үүгээр өндөрлөж байна.

Хуралд идэвхтэй оролцсон нийт хувьцаа эзэмшигчдэдээ баярлалаа. Та бүхний ажил, амьдралд сайн сайхныг хүсье. Баярлалаа.

Хувьцаа эзэмшигч Ж. Энхтунгалаг: Танай компанийн хамт олонд ажлын амжилт хүсье. Хурал 12 цаг 55 минутанд дуусав.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Тооллогын комиссын гишүүн



Г. Сувдаа